








BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

<p>Батлав.</p> <p>ТУЗ-ийн дарга  Аринболд</p> <p></p>	<p>Боловсруулсан:</p> <p>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  О.Билгүүн</p> <p>Хянасан:</p> <p>ТУЗ-ийн гишүүн  Ч.Зоригтбаатар</p> <p>Баталсан тогтоол: 2023.12.09</p>	
<p>Баримт бичгийн код: MBW-BOD-03</p>	<p>Хувилбар № 01</p>	<p>Шинэчилсэн:</p>

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

<p>Баримт бичгийн төлөв:</p> <p><input checked="" type="checkbox"/> Эх хувилбар</p> <p><input type="checkbox"/> Хуулбар</p> <p><input type="checkbox"/> Хүчингүй</p>	<p>Дардас</p>
--	---------------

	Цалин урамшууллын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-03	Шинэчилсэн:

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү бодлогын зорилго нь “Монгол базальт” ХК-ийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, Гүйцэтгэх захирал, түүний багийн болон компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход оршино.

1.2 Холбогдох баримт бичиг:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн дүрэм
- Компанийн засаглалын кодекс
- Хөдөлмөрийн харилцааны холбоотой дүрэм, журам, заавар

1.3 Компани цалин хөлс, урамшууллын тогтолцоондоо дараах зарчмыг баримтална.

1.3.1 *Бизнесийн стратегитай уялдуулах* – урт хугацааны өсөлтийг бий болгож, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хүртээх ашгийг нэмэгдүүлэх, компанийн үнэ цэнийг өсгөх стратеги бодлоготой цалин хөлсний тогтолцоог уялдуулан тодорхойлно.

1.3.2 *Өрсөлдөхүйц байх* – Бид мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг сонгон шалгаруулж, тогтвор суурьшилтай ажиллуулахад шаардлагатай цалин хөлс, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.3.3 *Гүйцэтгэлд суурилах* – Ажлын гүйцэтгэлийн тодорхой хэмжигдэхүйц зорилго тавьж, гүйцэтгэлийг шударгаар үнэлэн урамшуулал олгоно.

1.3.4 *Хүний хөгжилд анхаарах* – Ажилтнуудын карьерийн ахиц дэвшил, хувь хүний хөгжилд анхаарч, албан тушаал дэвших, тасралтгүй суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Хоёр. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ


2.1 Гүйцэтгэх захирлын цалин хөлс нь үндсэн цалин болон нэмэгдэл, урамшууллаас бүрдэнэ. Гүйцэтгэх захирлын үндсэн цалин, урамшууллын хэмжээг тогтоохдоо ТУЗ мэргэжлийн өндөр ур чадвартай, гүйцэтгэх удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхижүүлэхэд хангалттай хэмжээний байх бодлогыг баримтална.

2.2 Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ, ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх зохицуулалтыг ТУЗ-тэй байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

Гурав. НИЙТ АЖИЛТНУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

3.1 Компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг хууль тогтоомжид нийцүүлэн, энэхүү бодлогод тодорхойлсон зарчмыг баримтлан Гүйцэтгэх захирал тогтооно.

3.2 Компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд үндэслэн нийт ажилтнуудын цалин, урамшууллын хэмжээг жил бүр тогтоож болно.

	Цалин урамшууллын бодлого	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-03	Шинэчилсэн:

3.3 Цалин урамшууллын хороо нь компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, цалин хөлсний тогтолцоо нь компанийн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Дөрөв. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь тогтмол, үндсэн цалин хөлстэй байна. Энэхүү цалин хөлс нь гишүүний чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвараа дайчлан ажиллах, гишүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэсэн байна.

2.2 ТУЗ-ийн гишүүнд үндсэн цалин хөлснөөс гадна дараах хэлбэрийн нэмэгдэл, урамшуулал олгож болох ба хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон дээд хязгаарын дотор олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.

- Хуралд оролцсон цалин
- Компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин

2.3 ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, нэмэгдэл урамшуулал олгох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

2.4 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин, урамшууллыг ТУЗ тогтооно.

Тав. ХЯНАЛТ САЙЖРУУЛАЛТ

5.1 ТУЗ, түүний дэргэдэх хороод болон гүйцэтгэх захирлын санал, дүгнэлтэд үндэслэн Цалин урамшууллын бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.2 Цалин урамшууллын бодлогын хэрэгжилтийг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж нийгэд мэдээлнэ.

--o0o--